



## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

### Төрийн болон орон нутгийн өмчийн Үзлэг тооллого явуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 09-ний 439 дүгээр тогтоол, Монгол Улсын Сангийн сайдын 2016 оны 04 сарын 06-ны 136 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явагдаж байгаатай холбогдуулан байгууллагын тоологын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй баталсугай. Үүнд:

Комиссын дарга	Э.Мөнх-Эрдэнэ	Спорт сургалт, дасгалжуулалт, уралдаан тэмцээн хариуцсан мэргэжилтэн
Гишүүд	Ж.Бямбасайхан	Судалгаа, шинжилгээ, материаллаг бааз хариуцсан мэргэжилтэн
	С.Саранцэцэг	Биеийн тамирын бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Мөнх-Орших	Дотоод ажил, архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн
	Б.Түвшинбаяр	Спортын бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг байгууллагын хэмжээнд 2016 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд явуулж, тооллого явуулах хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Тооллогыг тогтоосон хугацаанд чанартай, үнэн зөв явуулж, эд хөрөнгийн бүртгэлийг батлагдсан статистик мэдээллийн маягтын дагуу гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэхийг Комиссын дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, хариуцсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллахыг нийт ажилтануудад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын  
2016 оны *тав дугаар* сарын *30*-ны өдрийн  
*А/34* дугаар тушаалын хавсралт



### ТООЛЛОГО ЯВУУЛАХ ХУВААРЬ

д/д	Тооллого хийх газарууд	Хуваарьт өдрүүд	тайлбайн
1.	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын өрөө тасалгаануудын эд хогшил техник хэрэгсэлийг тоолох	2016.05.12-нд	
2.	Тооллогын дүнг нэгтгэх, холбогдох байгууллагад хүргүүлэх ажил	2016.05.19-нд	Тооллогын комиссын гишүүд нийтээр оролцоно.

Боловсруулсан: *Э.Мөнх-Эрдэнэ* Э.Мөнх-Эрдэнэ  
Хянасан: *А.Болдмаа* А.Болдмаа